



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2027 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/372

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор тус сумын Зөөлөнгийн давааны авто замын засвар, арчлалт хийх 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийн зардлыг аймгийн Замын сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2. Дээрх сумын авто замын засвар арчлалт хийх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-д, арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

